



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 0140

Хараат

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, 49 дүгээр зүйлийн 49.2.10 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Жугамтын гол” ХХК-ны гүйцэтгэсэн “Халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх” ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: - Т.Өлзийбат (Мал Эмнэлгийн тасгийн дарга)

Нарийн бичиг: -Э.Баярмаа (2 дугаар багийн Засаг дарга)

Гишүүн: -Ж.Чулуунтогтох (Нягтлан бодогч)

2. Гүйцэтгэлийн чанар үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч хүлээн авсан акт үйлдэж баталгаажуулахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Өлзийбат)-д үүрэг болгосугай.

3. Ажил хүлээлцсэн акт холбогдох бичиг баримтыг үндэслэн Засаг даргын Тамгын газрын өмчид бүртгэхийг нягтлан бодогч (Ж.Чулуунтогтох) -д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА А. ЭРДЭНЭСАЙХАН

4823000087